



Г ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ
СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ж.РАВДАНДОРЖ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.07 № 1/26 ЧАГ-САГ/2014/42/СДГА-Д/0ХК

Г Зөрчлийг арилгуулах тухай

“ЦДУС” ТӨХК-ИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД АУДИТ ХИЙХЭД ДООРХИ ЗӨРЧИЛ ИЛЭРЛЭЭ.
Үүнд:

1. Дэд станцын хашааг барих 483,4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг гүйцэтгүүлэхээр “Боорчи” ХХК-тай 2012 оны 3 дугаар сарын 10-нд 12/13 тоот гэрээ байгуулжээ. “Боорчи” ХХК нь гэрээт ажлыг 2012 оны 07 дугаар сарын 30-ны өдөр дуусган, хүлээлгэн өгөх үүрэг хүлээсэн боловч өнөөг хүртэл гүйцэтгэж дуусгаагүй байна.
2. “Ар Пи Энд Эй” ХХК-тай 118,1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Микропроцессорон хамгаалалт нийлүүлж, сууринуулж, туршилт тохируулгын ажил гүйцэтгүүлэхээр 2013 оны 08 дугаар сарын 19-ний өдөр Т/2013/05 тоот гэрээ байгуулсан байна. Дээрх ажлыг 9 дүгээр сарын 19-ний өдөр дуусгахаар гэрээнд заасан боловч хугацаандaa гүйцэтгээгүй байна.
3. Төв байрны урд талын хэсгийг тохижуулах 59,7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг Чойсамбуу ХХК-тай 13/45 тоот гэрээг байгуулан, гүйцэтгүүлсэн байна. Гэвч дээрх тохижилт нь 2013 оны 9 сард Гудамж төслийн замын өргөтгөлд орж, нураагдсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46.1.4-т заасан “худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах” 46.1.6 –д “бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 тоот тушаалаар баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1 заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ НЬ**:

Нэг. “Ар Пи Энд Эй” ХХК-аар гэрээт ажлыг гүйцэтгүүлж дуусгах, “Боорчи” ХХК-аас гэрээт ажил хугацаандaa гүйцэтгээгүйн алдангийг нэхэмжлэх, хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх, “Гудамж” төсөл болон холбогдох байгууллагаас замын өргөтгөлийн нөхөн олговорыг нэхэмжилж, компанийн Төрийн банк дахь 2418044940 тоот дансанд төвлөрүүлэх

Хоёр. Биелэлтийг 2014 оны 6 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг “ЦДУС” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ж.РАВДАНДОРЖ, Ерөнхий нягтлан бодогч С.Норовжамц нарт хариуцуулав.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР

Д.ГАНБИЛЭГ/

УХА0122

Akt, alban shaardлага-A4 бланк